



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/54

Номгон

Эзэмшил газрын талбайн хэмжээ
залруулж, нэр өөрчлөх тухай

Монгол Улсын "Газрын тухай" хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/24 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Баянхонгор аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь Политехникийн коллеж болж нэр өөрчлөгдсөн тул газар эзэмшлийн гэрчилгээг шинээр олгосугай.

2. Эзэмшил газрын талбайн хэмжээ зөрүүтэй байгаа тул талбайн хэмжээний зөрүүг арилган замын зурваст орсон 5238 м² газрыг нийтийн эдэлбэрийн зам талбайд шилжүүлж хавсралтад дурдсаны дагуу 26483 м² болон 1979 м² газруудыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

3. Эзэмшил газрын талбайн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотойгоор газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /Т.Норов/-т үүрэг болгосугай.

4. Эзэмшил газрын 10 хувийг цэцэрлэгжүүлэн зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг Баянхонгор аймаг дахь Политехникийн коллежийн захирал /Д.Бат-Орших/-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Д.Ихбаяр/-т даалгасугай.



1190010

Аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын
31-ний өдрийн А/54 дүгээр захирамжийн
хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Д/д	Газар эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Байршил	Талбайн хэмжээ /м2/	Залруулагдаж буй талбайн хэмжээ /м2/	Эзэмших эрхийн хугацаа
1	Баянхонгор аймгийн Политехникийн коллеж	9007601	-	Боловсролын байгууллага	Баянхонгор сум, Номгон 1-р баг	33700 м2	26483 м2	15 жил
2				Автодром			1979 м2	

_____ 000